



144. ГААЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

1950 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталж,
1952 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хүчин төгөлдөр болсон*

Энэхүү конвенцид гарын үсэг зурсан Засгийн газар,

өөрийн гаалийн байгууллагын уялдаа, нэгдмэл ажиллагааг дээд зэргээр хангах, үүнтэй холбогдуулан ялангуяа гаалийн арга техник, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэгдсэн асуудлыг судлах нь зүйтэй гэж үзэж,

энэ салбар болон түүнтэй холбогдсон эдийн засаг, техникийн хүчин зүйлсийг харгалзан Засгийн газар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь олон улсын худалдааны ашиг сонирхолд нийцнэ гэдэгт гүнээ итгэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Үүгээр Гаалийн хамтын ажиллагааны Зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийг байгуулав.

2 дугаар зүйл

(a) Зөвлөлийн гишүүд нь:

- (i) Энэхүү конвенцийн Хэлэлцэн тохиролцогч Талууд;
- (ii) Дипломат харилцаагаа хэвийн явуулна гэдгийг нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал нотолж санал болгосон, гадаад худалдааны үйл ажиллагаагаа бие даан явуулж чадах, жинхэнэ гишүүнээр элсэхийг нь Зөвлөл зөвшөөрсөн, гаалийн нутаг дэвсгэр бүхий Засгийн газар байна.

(b) (a) хэсгийн (ii)-т заасны дагуу Зөвлөлийн гишүүн болж буй гаалийн нутаг дэвсгэр бүхий аливаа Засгийн газар, дипломат харилцаагаа хэвийн явуулна гэдгийг нотолсон Хэлэлцэн тохиролцогч Талаар дамжуулан гишүүнээс гарах тухайгаа Зөвлөлд мэдэгдсэн өдрөөс эхлэн гишүүн биш болно.

(c) Гишүүн бүр нэг төлөөлөгч, нэг буюу түүнээс дээш орлогчийг Зөвлөлд өөрийн төлөөлөгчөөр томилно. Эдгээр төлөөлөгч нь өөрийн зөвлөлтэй байж болно.

(d) Зөвлөл нь гишүүн бус Засгийн газар буюу олон улсын байгууллагын төлөөлөгчийг ажиглагчаар ажиллахыг зөвшөөрч болно.

3 дугаар зүйл

Зөвлөлийн үүрэг нь:

(a) энэхүү конвенцийн үндсэн зорилгын дагуу Хэлэлцэн тохиролцогч Талууд хөгжүүлэхээр тохирсон гаалийн талаарх хамтын ажиллагаатай холбоотой асуудлыг судлах;

*Монгол Улс 1991.05.31-ний өдөр нэгдэн орсон



(b) ажлын уялдаа, нэгдмэл ажиллагааг аль болох дээд зэргээр хангахад чиглэсэн практик арга замыг гишүүн улсын өмнө дэвшүүлэн тавих үүднээс гаалийн системийн техникийн асуудал болон түүнтэй холбоотой эдийн засгийн хүчин зүйлсийг шинжлэн судлах;

(c) конвенцийн төсөл болон түүний нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, сонирхогч Засгийн газарт түүнийг батлахыг зөвлөмж болгох;

(d) ажлын үр дүнд байгуулсан конвенц, түүнчлэн Европын гаалийн холбооны Судалгааны хэсгээс бэлтгэсэн Гаалийн тарифын жагсаалтад барааг ангилах нэрийн цогцсын тухай конвенц, Барааг гаалийн зорилгоор үнэлэх тухай конвенцийг нэг мөр тайлбарлан хэрэглэх явдлыг хангах зорилгоор зөвлөмж гаргах, түүнчлэн конвенцийн холбогдох заалтын дагуу Зөвлөлд шууд ногдуулсан үүргийг гүйцэтгэх;

(e) “(d)” хэсэгт дурдсан конвенцийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдсон маргааныг зохицуулахын тулд тэдгээрийн холбогдох заалтын дагуу эвлэрүүлэгчийн хувьд зөвлөмж гаргах;

(f) гаалийн хууль тогтоомж болон журмын холбогдолтой мэдээлэл түгээх ажлыг гүйцэтгэх;

(g) энэхүү конвенцийн үндсэн зорилгын хүрээнд өөрийн санаачилгаар, эсхүл сонирхогч Засгийн газрын хүсэлтээр тэдэнд гаалийн талаар мэдээлэл, зөвлөгөө бэлтгэж өгөх, мөн энэ талаар зөвлөмж гаргах;

(h) өөрийн эрх мэдлийн хүрээнд сонирхсон асуудлаар Засгийн газар хоорондын бусад байгууллагатай хамтран ажиллах.

4 дүгээр зүйл

Зөвлөлийг үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл болон бичиг баримт түүний хүсэлтээр гишүүн нь өгнө. Гэхдээ аливаа гишүүний хууль тогтоомжийн хэрэгжилтэд саад болохуйц нууц мэдээллийг задруулж, тараах буюу нийтийн эрх ашигт харш, эсхүл улсын болон хувийн аливаа үйлдвэрийн газрын хууль ёсны худалдааны эрх ашгийг зөрчсөн мэдээлэл шаардаж болохгүй.

5 дугаар зүйл

Зөвлөл нь Техникийн байнгын хороо, Ерөнхий нарийн бичгийн даргын газрын туслалцааг авч байна.

6 дугаар зүйл

(a) Зөвлөл нь гишүүн улсын төлөөлөгчдөөс дарга, хоёроос доошгүй орлогч даргыг жил бүр сонгоно.

(b) Зөвлөл нь өөрийн дотоод журмыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй олонхийн саналаар тогтооно.

(c) Зөвлөл нь Гаалийн тарифын жагсаалтад барааг ангилах нэрийн цогцсын тухай конвенцид зааснаар Нэрийн цогцсын хороо, Барааг гаалийн зорилгоор үнэлэх тухай конвенцид зааснаар Үнэлгээний хороог тус тус байгуулна. III зүйлийн (d) хэсэгт

заасан конвенцийн зорилгын дагуу, эсхүл өөрийн эрх мэдлийн хүрээнд бусад зорилгоор шаардлагатай гэж үзвэл өөр тийм хороодыг байгуулж болно.

(d) Зөвлөл нь Техникийн байнгын хорооны гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг нь тодорхойлно.

(e) Зөвлөл нь өөрийн жилийн төсвийг баталж, түүний зарцуулалтад хяналт тавих бөгөөд өөрийн санхүүтэй холбоотой заавар чиглэлийг Нарийн бичгийн даргын газарт өгнө.

7 дугаар зүйл

(a) Зөвлөлийн төв байр нь Брюссель хотноо байрлана.

(b) Зөвлөл, Техникийн байнгын хороо, Зөвлөлөөс байгуулсан аливаа хороо нь Зөвлөлийн шийдвэрээр түүний төв байрнаас өөр газар хуралдаж болно.

(c) Зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдаж байна. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноос гурван сарын дотор Зөвлөлийн анхны хуралдааныг хуралдуулна.

8 дугаар зүйл

(a) Зөвлөлийн гишүүн нь нэг удаа санал өгөх эрхтэй. Гэхдээ III зүйлийн (d) хэсэгт дурдсан хүчин төгөлдөр бөгөөд аливаа нэг гишүүний хувьд хэрэглэгдэхгүй байгаа конвенцийг тайлбарлах, хэрэглэх буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал өгөх эрхгүй.

(b) 6 дугаар зүйлийн (b) хэсэгт зааснаас бусад тохиолдолд Зөвлөлийн шийдвэрийг санал хураалтад байлцсан бөгөөд санал өгөх эрх бүхий гишүүдийн гуравны хоёрын саналаар батална. Тодорхой нэг асуудлаар санал өгөх эрх бүхий гишүүдийн талаас дээш хувь нь ирээгүй нөхцөлд уг асуудлаар Зөвлөл ямар нэг шийдвэр гаргахгүй.

9 дүгээр зүйл

(a) Зөвлөл нь Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний үндсэн, туслах болон төрөлжсөн байгууллага, түүнчлэн Засгийн газар хоорондын бусад байгууллагаас өмнөө тавьсан зорилтоо биелүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг тогтооно.

(b) Зөвлөл нь Засгийн газрын бус байгууллагын сонирхсон, өөрийн эрх мэдлийн хүрээн дэх асуудлаар тэдэнтэй зөвлөлдөх, хамтран ажиллах явдлыг хөнгөвчлөхөд шаардагдах арга хэмжээ авна.

10 дугаар зүйл

(a) Техникийн байнгын хороо нь зөвлөлийн гишүүдийн төлөөлөгчдөөс бүрдэнэ. Зөвлөлийн гишүүн нь нэг төлөөлөгч болон нэг буюу түүнээс дээш орлогчийг хороонд төлөөлөгчөөр томилж болно. Төлөөлөгчид нь гаалийн техник асуудлаар мэргэшсэн албан тушаалтан байна. Тэд өөрийн мэргэжилтэнтэй байж болно.

(b) Техникийн байнгын хороо нь жилд дөрвөөс доошгүй удаа хуралдана.

11 дүгээр зүйл

(a) Зөвлөл нь Ерөнхий нарийн бичгийн дарга, түүний орлогчийг томилох бөгөөд тэдний эрхлэн гүйцэтгэх ажил, чиг үүрэг, ажлын нөхцөл, хугацааг мөн тогтооно.



(b) Ерөнхий нарийн бичгийн дарга Ерөнхий нарийн бичгийн даргын газрын бүрэлдэхүүнийг томилно. Түүнийг байгуулах болон түүнд ажиллагсдын дүрмийг Зөвлөл батална.

12 дугаар зүйл

(a) Зөвлөл, Техникийн байнгын хороо болон Зөвлөлийн бусад хорооны төлөөлөгчийн зардлыг гишүүн улс өөрөө хариуцна.

(b) Зөвлөлийн зардлыг гишүүд хариуцах бөгөөд түүний хэмжээг Зөвлөл тодорхойлно.

(c) Төлөх татварын хэмжээг мэдэгдсэнээс хойш гурван сарын дотор түүнийг төлөөгүй гишүүний санал өгөх эрхийг Зөвлөл хасч болно.

(d) Гишүүн бүр Зөвлөлд элссэн санхүүгийн жилийн татвар болон гишүүнээс гарах тухай мэдэгдэл нь хүчин төгөлдөр болсон санхүүгийн жилийн татварыг тус тус бүрэн төлнө.

13 дугаар зүйл

(a) Зөвлөл нь өөрийн чиг үүргээ гүйцэтгэх шаардлагатай үед энэхүү конвенцийн хавсралтад тодорхойлсон эрх зүйн чадамжийг гишүүн бүрийн нутаг дэвсгэрт мөн эдэлнэ.

(b) Зөвлөл, гишүүн улсын төлөөлөгчид, тэдэнд туслахаар томилогдсон зөвлөх, мэргэжилтэн, мөн зөвлөлийн албан тушаалтан энэхүү конвенцийн хавсралтад тодорхойлсон эрх ямба болон дархан эрхийг эдэлнэ.

(c) Энэхүү конвенцийн хавсралт нь түүний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд конвенцоос хийх ишлэл нь түүний хавсралтад мөн хамаарна.

14 дүгээр зүйл

Энэхүү конвенцтой нэгэн зэрэг Брюссель хотноо гарын үсэг зурахад зориулан нээсэн Европын гаалийн холбооны Судалгааны хэсгийн тухай протоколын заалтыг Хэлэлцэн тохиролцогч Талууд хүлээн зөвшөөрч байна. Зөвлөл нь 12 дугаар зүйлийн (b) хэсэгт заасны дагуу татварын хэмжээг тодорхойлохдоо судалгааны группын гишүүн эсэхийг харгалзан үзнэ.

15 дугаар зүйл

Энэхүү конвенц нь 1951 оны 3 дугаар сарын 31-ийг хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

16 дугаар зүйл

(a) Энэхүү конвенцийг соёрхон батална.

(b) Батламж жуух бичгийг Бельгийн Гадаад хэргийн яаманд хадгалуулах бөгөөд тэр нь ийнхүү хадгалуулсан тухай, гарын үсэг зурсан болон нэгдэн орсон Засгийн газар бүрт, түүнчлэн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

17 дугаар зүйл

(a) Гарын үсэг зурсан долоон Засгийн газар батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсөн бол тэдний хувьд энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болно.

(b) Гарын үсэг зурсан Засгийн газар тус бүрийн хувьд энэхүү конвенц нь түүнийг баталж, батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсөн үеэс хүчин төгөлдөр болно.

18 дугаар зүйл

(a) Энэхүү конвенцид гарын үсэг зураагүй аль нэг улсын Засгийн газар 1951 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн түүнд нэгдэн орж болно.

(b) Нэгдэн орсон тухай баримт бичгийг Бельгийн Гадаад хэргийн яаманд хадгалуулах бөгөөд тэр нь ийхүү хадгалуулсан тухай гарын үсэг зурсан болон нэгдэн орсон Засгийн газар бүрт, мөн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

(c) Энэхүү конвенц 17 дугаар зүйлийн (a) хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсны дараа түүнд нэгдэн орж буй аливаа засгийн газрын хувьд түүнд нэгдэн орсон баримт бичгээ хадгалуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

19 дүгээр зүйл

Энэхүү конвенцийг хугацаагүйгээр байгуулсан хэдий боловч 17 дугаар зүйлийн (a) хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болсноос хойш таван жил өнгөрсний дараа Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал түүнээс гарч болно. Конвенцоос гарах тухай мэдэгдлийг Бельгийн Гадаад хэргийн яам хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Конвенцоос гарч байгаа тохиолдол бүрийг Бельгийн Гадаад хэргийн яам гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх Засгийн газар, мөн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

20 дугаар зүйл

(a) Зөвлөл нь энэхүү конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Хэлэлцэн тохиролцогч Талуудад санал болгож болно.

(b) Нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрч байгаа Хэлэлцэн тохиролцогч Тал энэ тухайгаа Бельгийн Гадаад хэргийн яаманд бичгээр мэдэгдэх бөгөөд Бельгийн Гадаад хэргийн яам зөвшөөрсөн мэдэгдлийн тухай гарын үсэг зурсан болон нэгдэн орсон Засгийн газар, мөн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

(c) Бельгийн Гадаад хэргийн яам зөвшөөрсөн тухай мэдэгдлийг Хэлэлцэн тохиролцогч бүх Талаас хүлээн авснаас хойш гурван сарын дараа уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно. Аливаа нэмэлт, өөрчлөлтийг Хэлэлцэн тохиролцогч бүх Тал хүлээн зөвшөөрвөл, Бельгийн Гадаад хэргийн яам хүлээн зөвшөөрсөн тухай бүрийг болон тухайн өөрчлөлт нь хүчин төгөлдөр болох хугацааг гарын үсэг зурсан, нэгдэн орсон бүх Засгийн газар, мөн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

(d) Тухайн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа түүнийг мөн хүлээн зөвшөөрөөгүй ямар нэг Засгийн газар энэхүү конвенцийг батлах буюу түүнд нэгдэн орохгүй.

Дээр дурдсаныг нотолж, өөрийн Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсон, дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун тавин оны арван хоёрдугаар сарын арван тавны өдөр (1950 оны 12 дугаар сарын 15-ны өдөр) Брюссель хотноо англи, франц хэлээр тус бүр нэг хувь үйлдсэн бөгөөд хоёр эх бичвэр нь адил хүчинтэй болно. Түүнийг Бельгийн Засгийн газрын архивт хадгалах бөгөөд баталгаат хуулбарыг нь гарын үсэг зурсан болон хүлээн зөвшөөрсөн Засгийн газар бүрт илгээнэ.



ГААЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН ХАВСРАЛТ

Зөвлөлийн эрх зүйн чадамж, эрх ямба, дархан эрх

1 дүгээр зүйл

Тодорхойлолт

I хэсэг

Энэ хавсралтад:

- (b) III зүйлийн зорилгод “үл хөдлөх хөрөнгө, актив хөрөнгө” гэсэн үг Зөвлөлийн үндсэн эрхийг өргөсгөхийн тулд үл хөдлөх хөрөнгө, сан гэсэн утгыг мөн агуулна.
- (c) 5 дугаар зүйлийн зорилгод “Гишүүдийн төлөөлөгчид” гэдэгт төлөөлөгч, орлогч, зөвлөх, техникийн ажилтан, нарийн бичиг нар бүгд орно.

2 дугаар зүйл

Эрх зүйн шийдвэр гаргагч этгээд

II хэсэг

Зөвлөл нь эрх зүйн шийдвэр гаргагч этгээд байна. Үүнд дараахь эрх зүйн чадамж хамаарна:

- (i) гэрээ байгуулах;
- (ii) үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө эзэмших, худалдах;
- (iii) эрх зүйн дүрэм батлах.

Эдгээр асуудлаар Зөвлөлийг төлөөлж Ерөнхий нарийн бичгийн дарга шийдвэр гаргана

3 дугаар зүйл

Үл хөдлөх хөрөнгө, сан, актив хөрөнгө

III хэсэг

Зөвлөлийн тусгай шийдвэрийн дагуу халдашгүй байдлаас нь чөлөөлснөөс бусад Зөвлөлийн үл хөдлөх хөрөнгө, актив хөрөнгө нь хаана орших, хэний эзэмшилд байгаагаас үл хамааран эрх зүйн үүднээс халдашгүй дархан байна.

IV хэсэг

Зөвлөлийн байр халдашгүй дархан байна.

Зөвлөлийн үл хөдлөх хөрөнгө хаана байрлах, хэний эзэмшилд байгаагаас үл хамааран нэгжих, албадан авах, хураан авах, журамлах болон аливаа бусад хэлбэрийн гүйцэтгэх албаны, захиргааны, шүүхийн, эсхүл хууль зүйн арга хэмжээнээс дархан байна.

V хэсэг

Зөвлөлийн архив болон түүнд хамаарах, эсхүл түүний мэдэлд байгаа бусад бүх баримт бичиг хаана байгаагаасаа үл хамааран халдашгүй дархан байна.

VI хэсэг

Аливаа санхүүгийн зохицуулалт, горим, эсхүл түр зогсоолтоор хязгаарлуулахгүйгээр:

- (i) Зөвлөл аль ч төрлийн валюттай байж болох бөгөөд аль ч төрлийн валютын данс ашиглаж болно;
- (ii) Зөвлөл өөрийн сангаасаа нэг улсаас нөгөө улс уруу, эсхүл аливаа улсад чөлөөтэй мөнгөн гуйвуулга хийж болох бөгөөд өөрт байгаа валютаа өөр аль ч валют руу шилжүүлж болно.

VII хэсэг

Зөвлөлийн ашиг сонирхолд хор учруулахгүйгээр төлөөлөгчөөр асуудлыг шийдвэрлүүлж болно гэж үзвэл дээрх VI дугаар хэсэгт тодорхойлсон эрхийг эдлэхдээ Зөвлөл өөрийн Гишүүдийн төлөөлөгчөөр дамжуулан үүргээ гүйцэтгэхийг эрхэмлэнэ.

VIII хэсэг

Зөвлөлийн актив хөрөнгө, орлого болон бусад үл хөдлөх хөрөнгө нь:

- (i) бүх шууд татвараас чөлөөлөгдсөн; Зөвлөл ус цахилгааны төлбөрөөс хэтрэхгүй татвараас чөлөөлөгдөх шаардлага тавихгүй;
- (ii) албан ёсны хэрэгцээнд импортлосон, эсхүл экспортлосон зүйлс нь гаалийн татвар, хориг, импорт-экспортын хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.
- (iii) Зөвлөлийн хэвлэл нь гаалийн татвар, хориг, импорт-экспортын хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.

IX хэсэг

Зөвлөл хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авахад онцгой албан татвараас болон тэдгээрийн үнэд шингэсэн татвараас ерөнхийдөө чөлөөлөгдөх хүсэлт тавихгүй боловч тийм татвар бүхий албан хэрэглээний чухал үл хөдлөх хөрөнгө худалдаж авах үед Зөвлөлийн гишүүд боломжтой бол уг татварыг бууруулан тооцох, эсхүл буцаан олгох арга хэмжээ авна.

4 дүгээр зүйл

Харилцаа холбооны байгууламж

X хэсэг

Бүх гишүүний нутаг дэвсгэр дээр Зөвлөл албан ёсны хэрэгцээний шуудан, кабел, телеграм, радиogramm, телезураг, телефон болон бусад харилцаа холбооны хэрэгсэл болон хэвлэл, радиод өгөх мэдээллийн тарифт тухайн гишүүн бусад улсын Засгийн газарт болон түүний дипломат төлөөлөгчийн газарт үзүүлдгээс дутахгүй тааламжтай үнэ, тариф болон татварын хэмжээ тогтооно.



XI хэсэг

Зөвлөлийн албан ёсны захидал харилцаа болон бусад албан ёсны харилцаа холбоонд аливаа хориг тавихгүй.

Энэ хэсэгт тодорхойлсон аль ч зүйл нь Зөвлөл, аль нэг гишүүн хооронд аюулгүй байдлыг хангах үүднээс байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилтийг хүчингүй болгох чиглэлээр ашиглагдахгүй.

5 дугаар зүйл

Гишүүдийн төлөөлөгчид

XII хэсэг

Зөвлөлийн, Техникийн байнгын хорооны болон Зөвлөлийн хороодын хуралд оролцох гишүүдийн төлөөлөгчид өөрийн эрх үүргээ биелүүлэх, хурал зохион байгуулж буй газарт очих, буцахдаа дараахь онцгой, дархан эрхийг эдэлнэ:

- (a) тэднийг баривчлах, эсхүл албадан саатуулахаас, эсхүл тэдний хувийн ачаа тээшийг саатуулахаас дархан байх бөгөөд тэдний албан ёсны журмаар хэлсэн үг, эсхүл хийсэн үйлдэл аливаа хууль сахиулах ажиллагаанд хамрагдахаас чөлөөлөгдсөн байх;
- (b) бүх баримт бичиг нь халдашгүй дархан байх;
- (c) код хэрэглэх, баримт бичиг хүлээж авах, элч илгээж захидлаар харилцах, эсхүл лацтай уут хэрэглэх;
- (d) гишүүд болон тэдний гэр бүлийн хүмүүс өөрийн эрх үүргээ гүйцэтгэх журмаар очих, эсхүл дамжин өнгөрч буй улсын цагаачлалын хязгаарлал, эсхүл гадаадын иргэний бүртгэлээс чөлөөлөгдөх;
- (e) валют, эсхүл валют солих хязгаарлалтын хувьд гадаадын төр засгийн төлөөлөгчдөд, эсхүл богино хугацааны албан ёсны ажлын айлчлалын үеэр үзүүлдэгтэй адил хөнгөлөлт үзүүлэх;
- (f) дипломат төлөөлөгчийн газрын гишүүдэд үзүүлдэг хувийн ачаа тээшийн халдашгүй дархан байдалтай адил эрх олгох.

XIII хэсэг

Зөвлөлийн, Техникийн байнгын хорооны болон Зөвлөлийн хороодын хуралд оролцож буй гишүүдийн төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангахын тулд үг хэлэх бүрэн эрх чөлөө, эрх үүргээ гүйцэтгэх бүрэн бие даасан байдал олгох бөгөөд эрх үүргээ гүйцэтгэх үедээ хэлсэн, эсхүл бичсэн үг, хийсэн үйлдэл нь хууль сахиулах ажиллагаанаас ангид байх бөгөөд тухайн этгээд дээрх эрх үүргээс чөлөөлөгдсөн байсан ч энэ эрх хэвээр байх болно.

XIV хэсэг

Гишүүдийн төлөөлөгчид эдгээр дархан эрх, эрх ямбыг зөвхөн Зөвлөлтэй холбоотой үйл ажиллагаа гүйцэтгэхэд эдлэх бөгөөд өөрийн хувийн ашиг сонирхолд ашиглаж болохгүй. Тиймээс гишүүн нь зөвхөн төлөөлөгчийн дархан эрхийг түдгэлзүүлэх эрхтэй бус гишүүний тодорхойлж байгаагаар энэ дархан эрх нь шударга ёсыг баримтлахад саад болж байна гэж үзэж буй тохиолдолд мөн дархан эрх олгосон шалтгаанд хохирол учруулалгүйгээр түдгэлзүүлж болох тохиолдолд төлөөлөгчийн дархан эрхийг түдгэлзүүлэх үүрэгтэй.

XV дугаар хэсэг

XII, XIII дугаар хэсгийн заалт нь холбогдох этгээд өөрөө иргэн нь болох, эсхүл төлөөлөгч нь болох улсын эрх мэдэлтэнд хамаарахгүй.

6 дугаар зүйл

Зөвлөлийн албан тушаалтан

XVI хэсэг

Энэ зүйлд тодорхойлогдох албан тушаалтны зэрэглэлийг Зөвлөл тодорхойлно.

Энэ зэрэглэлд багтсан албан тушаалтны нэрсийг Зөвлөлийн гишүүдтэй харилцсанаар Ерөнхий нарийн бичгийн дарга гаргана.

XVII хэсэг

Зөвлөлийн албан тушаалтан нь дараахь эрхтэй. Үүнд:

- (a) чиг үүргээ гүйцэтгэх үед болон өөрийн эрх мэдлийн хүрээнд хэлсэн үг, эсхүл хийсэн үйлдэл нь аливаа хууль сахиулах ажиллагаанаас ангид байх;
- (b) Зөвлөлийн зүгээс олгож буй цалин урамшуулал нь татвараас чөлөөлөгдсөн байх;
- (c) гэр бүлийн хүн болон тэдэнд хамаарах хамаатан нь цагаачлалын хязгаарлалт, гадаадын иргэний бүртгэлээс чөлөөлөгдөх;
- (d) ижил зэрэглэлийн дипломат төлөөлөгчийн газарт олгодог валют солих боломжийг олгох;
- (e) олон улсын ноцтой байдал үүсэх үед ижил зэрэглэлийн дипломат төлөөлөгчийн газарт үзүүлдэг эх оронд нь буцаах үйлчилгээг гэр бүлийн хүн болон тэдэнд хамаарах гишүүдэд үзүүлэх;
- (f) холбогдох улсад анх удаагаа ирэхдээ гэр ахуйн тавилга эдлэлээ гаалийн татваргүйгээр импортлох.

XVIII хэсэг

XVII дугаар хэсэгт олгосон эрх ямба, дархан эрхээс гадна олон улсын эрх зүйн дагуу олгодог дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнд олгодог эрх ямба, дархан эрх, хөнгөлөлтийг Ерөнхий нарийн бичгийн дарга болон түүний гэргий, 21 наснаас доош насны хүүхдэд нь мөн олгоно.

Ерөнхий нарийн бичгийн орлогч дарга нь ижил зэрэглэлийн дипломат төлөөлөгчдөд олгодог эрх ямба, дархан эрхийг эдлэнэ.

XIX хэсэг

Албан тушаалтан эдгээр дархан эрх, эрх ямбыг зөвхөн Зөвлөлтэй холбоотой үйл ажиллагаа гүйцэтгэхэд эдлэх бөгөөд өөрийн хувийн ашиг сонирхолд ашиглаж болохгүй. Ерөнхий нарийн бичгийн дарга нь зөвхөн албан тушаалтны дархан эрхийг түдгэлзүүлэх эрхтэй бус түүний тодорхойлж байгаагаар энэ дархан эрх нь шударга ёсыг баримтлахад саад болж байна гэж үзсэн тохиолдолд мөн дархан эрх олгосон шалтгаанд хохирол учруулалгүйгээр түдгэлзүүлж болох бол төлөөлөгчийн дархан эрхийг түдгэлзүүлэх үүрэгтэй. Ерөнхий нарийн бичгийн даргын дархан эрхийг Зөвлөл түдгэлзүүлэх эрхтэй.



7 дугаар зүйл

Зөвлөлийн нэрийн өмнөөс томилогдон ажиллах мэргэжилтэн

XX хэсэг

Зөвлөлийг төлөөлөн ажиллаж буй мэргэжилтэн (VI зүйлд тодорхойлсон албан тушаалтнаас өөр) эрх үүргээ гүйцэтгэх хугацаандаа бие даасан байдалтай байхад шаардлагатай дараахь эрх ямба, дархан эрх эдлэх бөгөөд үүнд ажил үүргээ гүйцэтгэх аяллын хугацаа мөн багтана. Үүнд:

- (a) тэднийг баривчлах, эсхүл албадан саатуулахаас, эсхүл тэдний ачаа тээшийг саатуулахаас дархан байх;
- (b) өөрийн чиг үүргийн хүрээнд, ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ хэлсэн, эсхүл бичсэн үг, хийсэн үйлдэл нь аливаа хууль сахиулах ажиллагаанаас ангид байх;
- (c) бүх баримт бичиг нь халдашгүй дархан байх.

XXI хэсэг

Мэргэжилтэн нь эдгээр дархан эрх, эрх ямбыг зөвхөн Зөвлөлтэй холбоотой үйл ажиллагаа гүйцэтгэхэд эдлэх бөгөөд хувийн ашиг сонирхолд ашиглаж болохгүй. Ерөнхий нарийн бичгийн дарга нь зөвхөн мэргэжилтний дархан эрхийг түдгэлзүүлэх эрхтэй бус, түүний тодорхойлж байгаагаар энэ дархан эрх нь шударга ёсыг баримтлахад саад болж байна гэж үзэж буй тохиолдолд мөн Зөвлөлийн эрх ашигт хохирол учруулалгүйгээр уг эрхийг түдгэлзүүлж болох бол мэргэжилтний дархан эрхийг түдгэлзүүлэх үүрэгтэй.

8 дугаар зүйл

Эрх ямбыг зүй бусаар ашиглах

XXII хэсэг

Зөвлөлийн, Техникийн байнгын хорооны болон Зөвлөлийн хороодын хуралд оролцож буй гишүүдийн төлөөлөгчид үүрэгт ажлаа гүйцэтгэж байхад болон хурал болох газарт очих, буцах үед нь, мөн 16, 20 дугаар хэсэгт тодорхойлсон албан тушаалтан өөрийн эрх үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байх үед нь тухайн улсын засаг захиргааны байгууллага тэднийг тус улсаас гарахыг албадан шаардаж болохгүй. Гэвч хэрэв дээрх этгээдийн аль нэг нь оршин суух эрх ямбаа тухайн улсад хийж гүйцэтгэх ёстой албан үүргээс өөр үйл ажиллагаанд зүй бусаар ашигласан тохиолдолд тухайн улсын Засгийн газар дараахь нөхцөлийг баримтлан нутаг дэвсгэрээсээ албадан гаргаж болно:

- (i) Зөвлөлийн гишүүдийн төлөөлөгчид, эсхүл XVIII дугаар хэсэгт тодорхойлсон дипломат дархан эрх эдлэх этгээдийг тухайн улсад суугаа дипломат төлөөлөгчид хамаарах журамд зааснаас өөрөөр тухайн улсаас гарахыг шаардаж болохгүй.
- (ii) XVIII дугаар хэсэгт хамаарахгүй албан тушаалтныг зөвхөн тухайн улсын Гадаад хэргийн яамны зөвшөөрлөөр гаргаж болох боловч уг зөвшөөрлийг олгохдоо Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргатай зөвшилцсөн байна. Хэрэв аль нэг албан тушаалтныг албадан хөөх шийдвэр гарсан бол Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн этгээдийг төлөөлж энэ үйл явцад оролцож болно.

XXIII хэсэг

Энэ хавсралтад тодорхойлсон эрх ямба, дархан эрхийг зүй бусаар ашигласан тохиолдол гарч буй эсэхийг Ерөнхий нарийн бичгийн дарга Зөвлөлийн гишүүдтэй хамтран ажиллаж байнга хянаж байх бөгөөд хууль дээдлэх ёс болон цагдан сэргийлэх журмыг сахиулахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

9 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

XXIV хэсэг

Зөвлөл дараахь асуудалд зохих шийдвэр гаргана:

- (a) гэрээнээс үүдэн гарах маргаан, эсхүл хувийн шинж чанартай боловч Зөвлөлийн гишүүнд хамааралтай бусад маргаан;
- (b) хэрэв 19, 21 дүгээр хэсгийн заалтын дагуу дархан эрх нь цуцлагдаагүй бол албан тушаалынхаа хүрээнд дархан эрх эдэлж буй Зөвлөлийн аливаа албан тушаалтанд хамаарах маргаан.

10 дугаар зүйл

Нэмэлт хэлэлцээр

XXV хэсэг

Зөвлөл аль нэг Хэлэлцэн тохиролцогч Тал, эсхүл Хэлэлцэн тохиролцогч Талуудтай энэ хавсралтын тухайн Хэлэлцэн тохиролцогч Талд, эсхүл тэдгээр Хэлэлцэн тохиролцогч Талуудад хамаарах заалтыг өөрчлөх нэмэлт хэлэлцээр байгуулж болно.

145. БАРААГ ТОДОРХОЙЛОХ, КОДЛОХ УЯЛДУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

*1983 оны 6 дугаар сарын 14-ний өдөр батлагдаж,
1988 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон**

УДИРТГАЛ

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн ивээл дор байгуулагдсан энэхүү конвенцийн Хэлэлцэн тохиролцогч Талууд,

олон улсын худалдааг хөнгөвчлөхийг хүсэж,

статистик мэдээлэл, нэн ялангуяа олон улсын худалдааны статистик мэдээлэл цуглуулах, харьцуулах болон дүн шинжилгээ хийх явдлыг хөнгөвчлөхийг хүсэж,

олон улсын худалдаанд барааны ангиллын нэг системээс нөгөөд шилжих явцад түүнийг дахин тодорхойлох, ангилах болон кодлохтой холбогдон гарч буй зардлыг багасгах, түүнчлэн худалдааны баримт бичгийг стандартчилах болон мэдээлэл дамжуулах ажиллагааг хөнгөвчлөхийг хүсэж,

технологийн хөгжил болон олон улсын худалдааны төлөв байдалд гарч буй өөрчлөлт нь 1950 оны 12-р сарын 15-ны өдөр Брюссель хотноо үйлдсэн Барааг гаалийн тарифт ангилах жагсаалтын тухай конвенцийг өргөн цар хүрээтэй болгон шинэчлэхийг шаардаж буйг харгалзаж,

гаалийн болон статистик мэдээллийн зориулалтаар Засгийн газар болон худалдааны эрх ашгийн үүднээс шаардаж буй үзүүлэлт нь дээр дурьдсан конвенцийн хавсралт жагсаалтаас хол давсныг харгалзаж,

*Монгол Улс 1991.05.31-ний өдөр нэгдэн орсон.